

Сангийн сайдын 2023 оны 12
дугаар сарын 25-ны өдрийн А/260
дугаар тушаалын хавсралт

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: *Даатгалын үйлчилгээ үзүүлэх*

Тендер шалгаруулалтын
дугаар: *ТБ/20240103206*

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер

ирүүлнэ.

6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б. АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр

төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд 14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал 15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг 16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс

бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр

өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- 27. Тендерийн талаар тодруулга авах** 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсхийг хянан үзэх** 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх** 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.
- 30. Арифметик алдааг залруулах** 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** 31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** 32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер

ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

33. Тендерийг эрэмбэлэх

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

35. Мэдэгдэл хүргүүлэх

35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

36. Гүйцэтгэлийн баталгаа

36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

37. Урьдчилгаа төлбөр

37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх

гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

**39. Тендер
гомдол**

шалгаруулалтын 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: ТӨРИЙН БАНК ХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Даатгалын үйлчилгээ үзүүлэх
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ТБ/20240103206/01/01
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгө
ТШЗ 2.1	<p>Нийт төсөвт өртөг: 439,274,013 (Дөрвөн зуун гучин есөн сая хоёр зуун далан дөрвөн мянга арван гурван) төгрөг</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилга, үл хөдлөх хөрөнгийн даатгал -140,666,937 төгрөг 2. Техник, тоног төхөөрөмжийн даатгал - 54,445,360 төгрөг 3. Тээврийн хэрэгслийн даатгал - 117,277,547 төгрөг 4. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал - 16,534,570 төгрөг 5. Мэргэжлийн хариуцлагын даатгал - 22,481,600 төгрөг 6. Ажилтны гэнэтийн осол, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал - 77,868,000 төгрөг 7. Бэлэн мөнгөний даатгал – 10,000,000 төгрөг
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн С.Энхтунгалаг Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, Худалдан авалтын үйл ажиллагааны хэлтэс, 2-р давхар, 202 тоот өрөө Утасны дугаар: 7505-1881 /4310/ Цахим шуудангийн хаяг: procurement@statebank.mn</p>
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй

ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: Шаардана</p> <p>ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.1.2-д заасны дагуу дараах лавлагаануудыг цахим системээр шалгана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа эсэх тодорхойлолт;</i> • <i>Тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон иргэний хэрэг, маргааны талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт;</i> • <i>Татвар болон Нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй эсэх тодорхойлолт;</i> 									
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> - <i>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 он тус бүрийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх.</i> - <i>Ашигтай ажилласан жилийн тоо: 2022, 2023 он тус бүр.</i> 									
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа 2022, 2023 он. /Цахим санхүүгийн тайлан “E-BALANCE” системд дээрх онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлан шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шаардлагатай мэдээллүүдийг шалгана/</i> - <i>Тендерт оролцогч нь тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар тодорхойлолт эсхүл Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан /Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани/ этгээдийн лавлагааг цахим системээр авч ирүүлнэ.</i> 									
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: Шаардана</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: Шаардана</p> <table border="1" data-bbox="451 1429 1484 1675"> <thead> <tr> <th data-bbox="451 1429 571 1512">Д/д</th> <th data-bbox="571 1429 1337 1512">Шаардлагатай боловсон хүчин</th> <th data-bbox="1337 1429 1484 1512">Ажилтны тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="451 1512 571 1594">1</td> <td data-bbox="571 1512 1337 1594">Төслийг хариуцан ажиллах, хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй, гэрээ хариуцсан ажилтан</td> <td data-bbox="1337 1512 1484 1594">1</td> </tr> <tr> <td data-bbox="451 1594 571 1675">2</td> <td data-bbox="571 1594 1337 1675">Захиалагчийн нөхөн төлбөрийн үйл ажиллагаа хариуцан ажиллах ахлах зэргийн ажилтан</td> <td data-bbox="1337 1594 1484 1675">1</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> - <i>Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шалгах тул ажилтнуудын регистрийн дугаарыг ирүүлнэ.</i> - <i>Санал болгож буй ажилтан нь сүүлийн 3 сар тухайн байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлагатай.</i> <p>Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягт 7, 10-ын дагуу ирүүлнэ.</p> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана</p>	Д/д	Шаардлагатай боловсон хүчин	Ажилтны тоо	1	Төслийг хариуцан ажиллах, хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй, гэрээ хариуцсан ажилтан	1	2	Захиалагчийн нөхөн төлбөрийн үйл ажиллагаа хариуцан ажиллах ахлах зэргийн ажилтан	1
Д/д	Шаардлагатай боловсон хүчин	Ажилтны тоо								
1	Төслийг хариуцан ажиллах, хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй, гэрээ хариуцсан ажилтан	1								
2	Захиалагчийн нөхөн төлбөрийн үйл ажиллагаа хариуцан ажиллах ахлах зэргийн ажилтан	1								

	<p>Шуурхай дуудлагын автомашин 1-ээс доошгүй байх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тээврийн хэрэгслийн гэрчилгээ (Өөрийн эзэмшлийнх бол) ирүүлнэ. - Эсхүл мэргэжлийн дуудлагын үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран ажиллах гэрээний хуулбар ирүүлнэ. - Техник хэрэгслийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан хянан үзэх тул “улсын дугаар”-ын мэдээллийг ирүүлнэ. <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана</p> <p>2022, 2023 он тус бүр Техникийн тодорхойлолтод заагдсан 7 нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүний 3-аас доошгүй төрөлд даатгалын үйлчилгээ үзүүлсэн гэрээний нийлбэр /он тус бүрийн нийлбэр/ дүн нь батлагдсан нийт төсөвт өртөг /439,274,013 төгрөг/-ийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчилгээ үзүүлсэн гэрээний хуулбар ирүүлнэ. - Үйлчилгээ хүлээлцсэн акт /гэрээ дүгнэсэн акт/ эсхүл захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардахгүй</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: Шаардахгүй</p>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ. 2. 2022, 2023 он тус бүрийн төлбөрийн чадварын зохистой харьцааны үзүүлэлт нь 110 % болон түүнээс дээш байх. /Санхүүгийн зохицуулах хорооны албан тоотоор баталгаажуулж ирүүлэх/. 3. Даатгагдсан хөрөнгийн хохирлын нөхөн олговрыг түргэн шуурхай олгох, нөхөн олговор түргэн шуурхай олгоогүйн улмаас үүсэх зардлыг бүрэн хариуцахыг баталсан албан бичиг ирүүлнэ.
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардана</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон Даатгалын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байх. (Техникийн тодорхойлолтод заагдсан 7 нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүн тус бүрт тохирох зөвшөөрөлтэй байх)</p>
ТШЗ 21.4	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: Тохируулахгүй тогтмол байна</p>
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: 2,196,370 /Хоёр сая нэг зуун ерэн зургаан мянга гурван зуун далан төгрөг/</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: ТБОНӨХБАҮХАТ хуулийн 22.6-д заасан баримт бичиг.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p>

	Огноо: <i>2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i>
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <i>2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 10 минут</i> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө</i>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <i>Үгүй.</i>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>Тийм</i> <i>Гүйцэтгэлийн баталгааг зөвхөн Төрийн банкаар гаргаж ирүүлнэ.</i>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр үнийн санал болон даатгалын хувийг дараах хүснэгтийн дагуу ирүүлнэ.

№	Даатгалын бүтээгдэхүүн	Төсөв /төгрөг/	Үнэлгээ /төгрөг/	Үнийн санал /Оролцогч бөглөх/	
				Дүн /төгрөг/	Хувь /%/
1	Барилга, үл хөдлөх хөрөнгийн даатгал	140,666,937	121,274,125,009		
2	Техник, тоног төхөөрөмжийн даатгал	54,445,360	37,120,606,559		
3	Тээврийн хэрэгслийн даатгал	117,277,547	12,716,754,663		
4	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	16,534,570	Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу		
5	Мэргэжлийн хариуцлагын даатгал	22,481,600	Нэг ажилтны хувьд: 1. Удирдах ажилтны хариуцлагын даатгал - 8,000,000 2. Ажилтны хариуцлагын даатгал - 3,000,000 3. Хөрөнгийн үнэлгээчний хариуцлагын даатгал - 150,000,000 4. Дилер ажилтны хариуцлагын даатгал - 500,000,000		
6	Ажилтны гэнэтийн осол, хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	77,868,000	Нэг ажилтны хувьд: 1. Гэнэтийн ослын даатгал - 2,500,000 2. Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал - 2,000,000		
7	Бэлэн мөнгөний даатгал	10,000,000	2,500,000,000		
	Нийт	439,274,013			

1: Барилга, үл хөдлөх хөрөнгийн даатгалын төсөв: 140,666,937 төгрөг

Даатгалын зүйл:

- Банкны барилга байгууламж, агуулах, граж буюу **хавсралт №1**-ын үл хөдлөх хөрөнгүүд.

Даатгалын хамгаалалт буюу эрсдэл:

- Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлтээс учирсан хохирол;
- Цахилгаан эрчим хүчний хэвийн бус хэлбэлзэл, хэт ачаалал, богино холболт, цахилгаан соронзон нөлөөлөл, цахилгаан гүйдлийн шууд бус нөлөөллөөс учирсан хохирол;
- Сантехникийн гэмтлээс үүсэх эрсдэл */сантехникийн ил далд шугам сүлжээний гэмтлийн улмаас ус алдах, ус чийг, механик гэмтлийн нөлөөлөл, байшин доторх дулааны хоолойн хөлдөлт, хугарлын нөлөөгөөр учрах хохирол гэх мэт/;*
- Байгалийн эрсдэл */газар хөдлөлт, хөрсний нуралт, аадар бороо, мөндөр, гол усны үер, аянга цахилгаан, цасан болон шороон шуурга, хүчит салхи гэх мэт/;*
- Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүйгээр учруулсан аливаа хохирол;
- Ажилтнуудын санамсар болгоомжгүй үйлдлээс учирсан аливаа хохирол;
- Хулгай, дээрмийн сэдлээр учирсан хохирол.

Нэмэлт үйлчилгээ:

- Даатгалын хохирол үнэлгээний зардал.

Нөхөн төлбөр олгох нөхцөл:

- Учирсан хохирлын хэмжээгээр 100%-иар нөхөн төлбөрийг олгох;
- Даатгалын эрсдэлийн улмаас учирсан эсвэл учирч болзошгүй хохирлын хэмжээг багасгахын тулд даатгуулагчийн авсан арга хэмжээний зардлыг даатгалын нөхөн олговор дээр нэмж даатгуулагчид нөхөн төлөх.

Нөхөн төлбөр бүрдүүлэх материал:

- Даатгуулагчийн өргөдөл, албан бичиг;
- Хохирлын үнэлгээ;
- Шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт */Энэхүү гэрээнд заасан нөхөн төлбөр олгохгүй нөхцөл бүрдсэн эсэхийг шалгах шаардлагатай гэж үзэж хуульд заасны дагуу тухайн цаг хугацаанд уг баримт үйлдэгдэх боломжтой тохиолдолд хамаарна/.*

Нөхөн төлбөр олгох хугацаа:

- 0-5 хоног хүртэл.

Үйлчилгээний хугацаа:

- 24 цагаар 7 хоногийн турш.

Даатгалын хугацаа:

- 1 жил.

Даатгуулагчийн буруутай тохиолдолд өөрийн хүлээх хариуцах хувь:

- Байхгүй.

Даатгалын үйлчилгээний үргэлжлэх хугацаа:

- 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 00:00 цагаас эхлэн 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 24:00 цаг хүртэл.

2: Техник, тоног төхөөрөмжийн даатгалын төсөв: 54,445,360 төгрөг

Даатгалын зүйл:

Хавсралт № 2, 3-т заасан Банкны техник, тоног төхөөрөмжүүд.

Даатгалын хамгаалалт буюу эрсдэл:

- Байгалийн эрсдэл /газар хөдлөлт, хөрсний нуралт, аадар бороо, мөндөр, гол усны үер, аянга цахилгаан, цасан болон шороон шуурга, хүчит салхи гэх мэт/;
- Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлтээс учирсан хохирол;
- Цахилгаан эрчим хүчний хэвийн бус хэлбэлзэл, хэт ачаалал, богино холболт, цахилгаан соронзон нөлөөлөл, цахилгаан гүйдлийн шууд бус нөлөөллөөс учирсан хохирол;
- Сантехникийн гэмтлээс үүсэх эрсдэл /сантехникийн ил далд шугам сүлжээний гэмтлийн улмаас ус алдах, ус чийг, механик гэмтлийн нөлөөлөл, байшин доторх дулааны хоолойн хөлдөлт, хугарлын нөлөөгөөр учрах хохирол гэх мэт/;
- Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас учруулсан хохирол;
- Хулгай, дээрмийн үйлдлийн улмаас үүдсэн хохирол;
- Тээвэрлэх, зөөвөрлөх, буулгах, суурилуулах үеийн хохирол;
- Үйлдвэрийн осол, барилга нурах;
- Элдэв биет зүйлд цохиулах;
- Программ хангамжийн шинэчлэл, вирусын халдлага болон програмын шууд бус нөлөөллөөс учирсан хохирол;
- Тоног төхөөрөмжийн халалт, хэт ачаалал, хөдөлгөөнт эд ангийн механик гэмтлээс учирсан хохирол.

Нэмэлт үйлчилгээ:

- Даатгалын хохирол үнэлгээний зардал;
- Тээврийн зардал.

Нөхөн төлбөр олгох нөхцөл:

- Учирсан хохирлын хэмжээгээр 100%-иар нөхөн төлбөрийг олгох;
- Даатгалын эрсдэлийн улмаас учирсан эсвэл учирч болзошгүй хохирлын хэмжээг багасгахын төлөө Даатгуулагчийн авсан арга хэмжээний зардлыг даатгалын нөхөн олговор дээр нэмж Даатгуулагчид нөхөн төлөх.

Нөхөн төлбөр бүрдүүлэх материал:

- Даатгуулагчийн өргөдөл, албан бичиг;
- Хохирлын үнэлгээ /Мэдээллийн технологийн мэргэжлийн байгууллагын үнийн санал/;
- Шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт /Энэхүү гэрээнд заасан нөхөн төлбөр олгохгүй нөхцөл бүрдсэн эсэхийг шалгах шаардлагатай гэж үзэж хуульд заасны дагуу тухайн цаг хугацаанд уг баримт үйлдэгдэх боломжтой тохиолдолд хамаарна/.

Нөхөн төлбөр олгох хугацаа:

- 0-5 хоног хүртэл.

Үйлчилгээний хугацаа:

- 24 цагаар 7 хоногийн турш.

Даатгалын хугацаа:

- 1 жил.

Даатгуулагчийн буруутай тохиолдолд өөрийн хүлээх хариуцах хувь:

- Байхгүй.

Бусад:

- Даатгалын хөрөнгө болох Техник, тоног төхөөрөмжид даатгалын тохиолдол үүсэж шатаж, гэмтсэн тохиолдолд 3,000,000 төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий хохирол гарсан нөхцөлд холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан акт, дүгнэлт, тодорхойлолт заавал авах бөгөөд түүнээс доош үнийн дүн бүхий хохиролд Төрийн банкны инженерийн гаргасан акт, дүгнэлт, тодорхойлолтыг нөхөн төлбөрийн материалд бүрдүүлэн хавсаргана.

Даатгалын үйлчилгээний үргэлжлэх хугацаа:

- 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 00:00 цагаас эхлэн 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 24:00 цаг хүртэл.

3: Тээврийн хэрэгслийн даатгалын төсөв: 117,277,547 төгрөг

Даатгалын зүйл:

- Банкны өмчлөл, эзэмшилд байгаа **Хавсралт №4-т** заасан тээврийн хэрэгслүүд болон замын хөдөлгөөний дүрмээр зөвшөөрөгдсөн нэмэлт тоноглолуудын хамт орно.

Даатгалын хамгаалалт буюу эрсдэл:

- Зам тээврийн хөдөлгөөний бүх төрлийн осол /*Мөргөх, мөргөлдөх, мөргүүлэх, шүргэх, шүргэлдэх, шүргүүлэх, онхолдох, өндрөөс унах гэх мэт* /
- Галын эрсдэл / *Зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн галд шатах, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт, түлэгдэх, төөнөгдөх гэх мэт*/;
- Байгалийн эрсдэл /*зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн газар хөдлөлт, хөрсний нуралт, аадар бороо, мөндөр, гол усны үер, аянга цахилгаан, цасан болон шороон шуурга, хүчит салхи гэх мэт*/;
- Биет зүйл унах, үсэрсэн зүйлд оногдох /*Зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн*/;
- Аливаа гадны биетийн нөлөөгөөр салхины, хаалганы шил хагарах, гэмтэх /*Шороон зам дээр чулуу үсрэх, шувуу амьтан мөргөх гэх мэт*/;
- Тээврийн хэрэгсэлд цахилгааны богино холболтын улмаас үүссэн галын эрсдэл;
- Жолоо шилжүүлэх /*Даатгуулагчаас бусад этгээд тээврийн хэрэгслийг жолоодох үеийн зам тээврийн осол*/;
- Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас учрах бүх төрлийн эрсдэл /*зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн*/;
- Эд ангийн хулгай болон бүхэлд нь хулгайд алдах;
- Тээврийн хэрэгсэл зогсоол, зогсоолын зоиулалттай талбай, гаражид байх үеийн эрсдэл. Үүнд:
 - Тээврийн хэрэгслийг оруулах, гаргах, хөдөлгөх, байрлуулах үеийн;
 - Сантехникийн гэмтлээс үүсэх эрсдэл /сантехникийн ил далд шугам сүлжээний гэмтлийн улмаас ус алдах, ус чийгийн нөлөөлөл гэх мэт/;
 - Цахилгаан, эрчим хүчний хэлбэлзлийн улмаас үүсэх эрсдэл;
 - Барилгын нуралт.

Нэмэлт үйлчилгээ:

- 24 цагийн шуурхай дуудлага;
- Нөхөн төлбөр болон даатгалын зөвлөгөө;
- Даатгалын хохирол үнэлгээний зардал - баримтаар;
- Тээврийн хэрэгслийг зөөн тээвэрлэх зардал;
- Засварын дараах гадна дотор угаалгын зардал;
- Жолооч болон зорчигчийн гэнэтийн ослын зардал 1,000,000 төгрөг.

Нөхөн төлбөр олгох нөхцөл:

- Учирсан хохирлын хэмжээгээр 100%-иар нөхөн төлбөрийг олгох;
- Даатгалын эрсдэлийн улмаас учирсан эсвэл учирч болзошгүй хохирлын хэмжээг багасгахын тулд даатгуулагчийн авсан арга хэмжээний зардлыг даатгалын нөхөн олговор дээр нэмж даатгуулагчид нөхөн төлөх.

Нөхөн төлбөр бүрдүүлэх материал:

- Даатгуулагчийн өргөдөл, албан бичиг;
- Хохирлын үнэлгээ;
- Шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт / энэхүү гэрээнд заасан нөхөн төлбөр олгохгүй нөхцөл бүрдсэн эсэхийг шалгах шаардлагатай гэж үзэж хуульд заасны дагуу тухайн цаг хугацаанд уг баримт үйлдэгдэх боломжтой тохиолдолд хамаарна/.

Нөхөн төлбөр олгох хугацаа:

- 0-5 хоног хүртэл.

Үйлчилгээний хугацаа:

- 24 цагаар 7 хоногийн турш.

Даатгалын хугацаа:

- 1 жил.

Даатгуулагчийн буруутай тохиолдолд өөрийн хүлээх хариуцах хувь:

- Байхгүй.

Даатгалын үйлчилгээний үргэлжлэх хугацаа:

- 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 00:00 цагаас эхлэн 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 24:00 цаг хүртэл.

4. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын төсөв: 16,534,570 төгрөг

Даатгалын зүйл:

- Банкны өмчлөлийн **Хавсралт № 4-ын** тээврийн хэрэгслүүд.

Даатгалын хамгаалалт буюу эрсдэл:

- Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу.

Нөхөн төлбөр олгох нөхцөл:

- Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу.

Даатгалын үйлчилгээний үргэлжлэх хугацаа:

- 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 00:00 цагаас эхлэн 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 24:00 цаг хүртэл.

5: Мэргэжлийн хариуцлагын даатгалын төсөв: 22,481,600 төгрөг

Даатгалын зүйл: Хавсралт № 5

1. Банктай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй удирдах ажилтны хариуцлага;
2. Банктай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй ажилтны хариуцлага;
3. Банкны хөрөнгийн үнэлгээчин чиг үүргийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гаргасан алдаа, дутагдал;
4. Банкны дилер чиг үүргийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гаргасан алдаа, дутагдал.

Даатгалын үнэлгээ:

- Удирдах ажилтны хариуцлагын даатгалын нэг удирдах ажилтны үнэлгээг 8,000,000 /найман сая/ төгрөгөөр;
- Ажилтны хариуцлагын даатгалын нэг ажилтны үнэлгээг 3,000,000 /гурван сая/ төгрөгөөр;
- Мэргэжлийн хариуцлагын даатгал-Хөрөнгийн үнэлгээчин нэг ажилтны үнэлгээг 150,000,000 /нэг зуун тавин сая/ төгрөгөөр;
- Мэргэжлийн хариуцлагын даатгал-Банкны дилер нэг ажилтны үнэлгээг 500,000,000 /таван зуун сая/ төгрөгөөр.

Даатгалын хамгаалалт буюу эрсдэл:

1. Банктай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй удирдах ажилтны хариуцлага:
